

ӨГҮҮЛЭЛ

Энэтхэг-Номхон далайд явуулж буй Британийн гадаад бодлого ба Монгол Улс**Түвшинжаргалын Анударь^{ID}**

Шинжлэх Ухааны Академийн Олон улс судлалын хүрээлэн,
Улаанбаатар, Монгол Улс
anudari_t@mas.ac.mn

Хураангуй: Британийн өнөөгийн гадаад бодлогыг судлахад эзэнт гүрнийх нь үеэс улбаатай баялаг түүх, түүхэн байр суурь, уламжлалт бодлогыг нь зайлшгүй авч үзэх шаардлагатай болдог. Ази, Африк, Америк, Австрали, цаашилбал бүр Европ тивд ч олон улс орон, газар нутгийг захирч явсан, өдгөө ч колоничилж байсан зарим газартаа нөлөөгөө хадгалсаар байгаа бөгөөд өөрийн хүрээлэлдээ нягт холбоотой ажилласаар буй зэргээрээ Британийн гадаад бодлого их гүрний шинжийг агуулсаар байдаг өвөрмөц онцлогтой.

Колоничлогчийн байр сууринаас дэлхийн хэмжээний бодлого тодорхойлж, түүнээ урт хугацаанд хэрэгжүүлж чадсан Британийн гадаад бодлогод БРЕКСИТ хэрхэн нөлөөлөв, өнөөгийн олон улсын харилцаанд илэрч буй сорилт бэрхшээлд Британи хэрхэн дасан зохицож, гадаад бодлогынхоо аль чиглэлд ямар бодлогын шилжилт хийж байна гэдэг нь манай улсын анхаарлын төвд байх нэг чухал асуудал мөн бөгөөд үүний учир шалтгаан нь Британи бол Европоос Монгол Улстай анхлан дипломат харилцаа тогтоосон улс мөний дээр манай гуравдагч хөршийн бодлогын чухал нэгэн субъект болоход оршино. Энэхүү өгүүлэлд БРЕКСИТ-ээс хойш Британийн гадаад бодлогод ямар өөрчлөлт гарсан, яагаад тус улс Энэтхэг-Номхон далайн бүс нутагт илүүтэй анхаарч, идэвхийлэн ажиллах болсон хийгээд энэхүү бодлого нь Монгол Улсад хэрхэн илэрч байна гэдгийг тусгайлан судалж, санал дүгнэлт гаргахыг зорив.

Түлхүүр үгс: Британийн гадаад бодлого, Энэтхэг-Номхон далайн бүс нутаг, Олон улсын хөгжлийн стратеги, Монгол-Британийн харилцаа



Удиртгал

2020 онд эцэслэгдсэн БРЕКСИТ¹-ээс хойш өнөөг хүртэлх дөрөвхөн жилийн хугацаанд дэлхий дахинаа болон Британи Улсад олон улсын дэг журмыг өөрчлөх хэмжээний томоохон үйл явдлууд ар араасаа тасралтгүй өрнөсөн нь тус улсын өнөөдрийн гадаад бодлогыг тодорхойлох үндсэн нөхцөл болж өгчээ. Британийн өнөөгийн гадаад бодлогыг бүрэлдүүлсэн гадаад нөхцөл байдалд ковид-19 цар тахал, ОХУ-аас Украинд хийсэн довтолгоо, Израил-Хамасын зэвсэгт мөргөлдөөн зэргийг хамаатуулж болох бол дотоод нөхцөл байдалд нь 2022 оны шил дараалсан онцгой үйл явдлуудыг тусгайлан авч үзэх нь зүйтэй. 2022 он бол Британийн хувьд онцгой жил байсан хэмээж болох бөгөөд ганцхан тус жилийн дотор, бүр тодруулбал ердөө дөрвөн сарын хугацаанд гурван Ерөнхий сайдыг үзэж, 70 жилийн турш хаан ширээнээ заларсан Хатан хаан II Элизабет таалал төгсөж, улмаар шинэ хааныг хаан ширээнд залсан билээ.

Эдгээр үйл явдлууд, гэнэтийн огцом өөрчлөлтүүд, түүнээс улбаалсан үрнөлөө нь Британийг цаг тутам сорьж, улам бүр хүчирхэгжихийг шаардахын хэрээр Британи гадаад бодлогодоо анхаарах, шинэчлэх шаардлага үүссэн. Үүний

дүнд 2021 онд олон улсын өнөөгийн чиг хандлага, шинэ дэг журамд зохицсон бодлого бүхий “*Integrated Review of Security, Defence, Development and Foreign Policy*” аюулгүй байдал, батлан хамгаалах, гадаад бодлогын баримт бичгийг батлахдаа анх удаа Энэтхэг-Номхон далайн стратегийг дэмжиж буйгаа илэрхийлж, Энэтхэг-Номхон далайн бүс нутгийг гадаад бодлогын нэгэн чухал чиглэл болгон зарласан. Удалгүй, Орос-Украины дайн, БНХАУ-ын тус бүс нутагт явуулж буй бодлогын нөлөөгөөр энэхүү баримт бичгээ ахин өөрчлөх шаардлага үүссэн учир 2023 онд “*Integrated Review Refresh*”-ийг танилцуулахдаа Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн ач холбогдол улам нэмэгдэж буйг тэмдэглээд, гадаад бодлогынхоо нэг тулгуур багана болгож буйгаа зарлан, ингэснээрээ тухайн бүс нутагт хандуулж буй Британийн гадаад бодлого цаашид улам эрчимжих нөхцөл үүссэн билээ.

Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн тухай ойлголт их гүрнүүдийн хувьд ялгаатай байдаг бөгөөд АНУ, Япон, Австрали зэрэг томоохон тоглогч улсууд өөрсдийн Энэтхэг-Номхон далайн стратегид² Монгол Улсыг нэр зааж оруулсан байдаг. Жишээ нь АНУ

¹ Брексит гэдэг нь Britain Exit гэсэн үгний товчлол. 2016 оны 6 дугаар сарын 23-ны өдөр Британийн ард түмэн түүхэн сонголт хийх санал асуулгад оролцож 52:48-ын харьцаатай дүнгээр Европын Холбооноос гарах шийдвэр дээр санал нэгдсэн. Санал асуулгаас хойш 3,5 жилийн дараа буюу 2020 оны 1 дүгээр сарын 31-ний өдөр 47 жил үргэлжилсэн Британийн гишүүнчлэл албан ёсоор дуусгавар болсон билээ.

² 2007 онд Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн улс орнууд өөрсдийн эдийн засаг, батлан хамгаалах, аюулгүй байдлаа хангах тухай *Free and Open Indo-Pacific Strategy* буюу “Чөлөөт, нээлттэй Энэтхэг-Номхон далай” гэсэн ойлголтыг танилцуулж, 2016 онд албан ёсоор стратеги болгон баталсан. 2019 онд АНУ мөн уг стратегийг албан ёсны болгож, түүнээс хойш бусад орнууд энэ стратегийг дэмжин оролцох болсон.

өөрийн стратегидээ Монгол Улсыг 17 удаа дурдсан байдаг ажээ³.

Тэгвэл Британийн гадаад бодлогын дээрх баримт бичгүүдэд манай улсын нэр дурдагдаагүй байгаа нь судлаачийн анхаарлыг татсан бөгөөд үүнээс үүдээд Энэтхэг-Номхон далайн бүс нутагт явуулж буй Британийн гадаад бодлого Монгол Улсад хэрхэн илэрч байгаа талаар энэхүү судалгаагаараа гаргаж ирэхийг зорьлоо. Ингэхдээ Британи улсын бодлогын баримт бичгүүдэд дүн шинжилгээ хийж, өнөөдрийн хоёр орны харилцааны нөхцөл байдлыг судалснаар бодлого, төлөвлөлт бодит амьдрал дээр хэрхэн туссаныг гаргах замаар тодорхойлох юм.

Өнөөдөр дэлхийн томоохон

гүрнүүдийн сонирхлыг татаж, анхаарлын төвд эрхгүй орж ирсэн Энэтхэг-Номхон далайн бүс нутаг, энд орших улсууд өөрсдийн өсөн нэмэгдэж буй ач холбогдлоо үнэлэн, томоохон гүрнүүдийн баримталж буй бодлогод ямар хариу үйлдэл үзүүлэх, хэрхэн өөрсдийн эрх ашигтаа уялдуулан бодлогоо тодорхойлох нь зайлшгүй анхаарал татаж байна. Британи Энэтхэг-Номхон далайд нэгэнт анхаарлаа эргүүлсэн энэ үед Монгол Улс өөрийн эзлэх байр сууриа ойлгож авах нь тус улстай харилцах харилцаандаа баримтлах хэтийн бодлогыг тодорхойлоход хувь нэмэр оруулах ач холбогдолтой юм.

1. Энэтхэг-Номхон далайд явуулж буй Британийн гадаад бодлого

2021 онд батлагдсан “*The Integrated Review of Security, Defence, Development and Foreign Policy*” гэх уг баримт бичгээр Британи Энэтхэг-Номхон далайн бүс нутагт анхаарлаа нэмэх болсныг хэд хэдэн учир шалтгаантай холбон тайлбарлаж болно. Юуны өмнө газар зүйн байршлын түүхэн учир шалтгаан буюу эзэнт гүрний үеийнх нь колони эзэмшлийн хүрээнд байсан Хамтын нөхөрлөлийн хэд хэдэн гишүүн орон (Бангладеш, Энэтхэг, Малайз, Малдив, Сингапур, Австрали, Шинэ Зеланд) энэ бүс нутагт оршдог. Удаад

нь, хүн ам зүйн болон эдийн засгийн ач холбогдлын шалтгаан. Учир нь тус бүс нутагт 1,7 сая Британи хүн оршин суудаг гадна дэлхийн нийт хүн амын тал хувийг эзлэх асар их хүн ам зүйн нөөцтэйн дээр дэлхийн ДНБ-ий 40%-ийг эзэлдэг хамгийн эрчимтэй өсөж буй эдийн засаг юм⁴. Гутгаарт, геополитик аюулгүй байдлын учир шалтгаан буюу БНХАУ-ын нөлөө, үйл ажиллагааг хязгаарлахад чиглэсэн “Энэтхэг-Номхон далайн стратеги”⁵-ийг хамгаалахад оролцох тус улсын эрмэлзлэлтэй холбоотой байна.

³ Ж.Оргил-Эрдэнэ, “АНУ-ын Энэтхэг-Номхон далайн стратеги: Их гүрнүүдийн өрсөлдөөний эрин үе дэх АНУ-Монголын харилцаа”, Энэтхэг-Номхон далайн үзэл санаа: Оролцогч орнуудын байр суурь, Улаанбаатар, 2022, 25 дугаар тал

⁴ The Integrated Review of Security, Defence, Development and Foreign Policy, 2021

⁵ 2007 онд Япон Улсын Ерөнхий сайд Шинзо Абэ *Free and Open Indo-Pacific Strategy* буюу “Чөлөөт, нээлттэй Энэтхэг-Номхон далай” гэсэн ойлголтыг танилцуулж, 2016 онд албан ёсоор стратеги болгон баталсан. 2019 онд АНУ мөн уг стратегийг албан ёсны болгож, түүнээс хойш бусад орнууд энэ стратегийг дэмжин оролцох болсон.

Тус баримт бичигт Энэтхэг-Номхон далайн стратегийн гол ойлголт болох “Чөлөөт, нээлттэй Энэтхэг-Номхон далай”-г цогцлоход Британи онцгой ач холбогдол өгч, Британи Улс тус бүс нутаг дахь Европ тивийн хамгийн дотно, урт хугацааны гүнзгий харилцаатай, найдвартай түнш байх болно гэж тусгажээ. Түүнчлэн тухайн бүс нутгийн хөгжил нь Британийн болоод олон улсын аюулгүй байдал, эдийн засагт шууд нөлөөтэй бөгөөд энэ бүс нутагт аль нэгэн хүч давамгайлсан бус, бүс нутгийн улс орнууд олон түнш улсуудтай нээлттэй харилцах боломжтой, чөлөөт байх нөхцөлийг хангаснаар ямарваа нэгэн гадны нөлөө, шахалт дарамтгүйгээр өөрсдийн сонголтоо хийх бүрэн эрх чөлөөтэй байж, тогтвортой бүс нутаг бүрдэх үндэс болно. Энэ бүс нутгийг нээлттэй, тогтвортой бүс нутаг болгоход Британи өөрийн олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийнхээ дагуу дэмжин оролцоно гэдгээ тэмдэглэжээ⁶.

Онолын үүднээс Британийн гадаад бодлогын эл шилжилтийг ажиглавал Хүчний тэнцвэрийн онолоор тайлбарлаж болох бөгөөд мөн реалист онолын суурь ч ажиглагдаж байгаа юм. Учир нь өнөөдрийн олон улсын харилцааны өрнөл, түүний хурдац нь зөвхөн дан ганц нэг, хоёр онолын

ойлголтоор тайлбарлагдахгүй бүхэлдээ олон улсын харилцааны онолуудын цогц нийлэмжээр тайлбарлагдах шинжтэй болсноороо өмнөх түүхэн цаг үеүдээс ялгагдаж байна⁷. Өнөөдөр судлаачдын үзэж буйгаар дэлхий ертөнц ахин хоёр туйлт системд хуваагдах нөхцөл үүссэн энэ үед Британи мөн аль нэгэн улс олон улсын тавцанд гол тоглогч болохоос сэргийлэн хүчний тэнцвэр барихыг эрмэлзэж байгаа нь Энэтхэг-Номхон далайн бүс нутагт БНХАУ-ын эрх мэдлийг тогтоон барих, эсэргүүцэх бодлогоос нь харагдана. Түүнчлэн, БРЕКСИТ-ээс хойш дангаар бодлогоо тодорхойлон, бие даасан тоглогч болохоор шийдвэрлэсэн явдлаас харвал тухайн улсын явуулж буй гадаад бодлогыг үндэсний аюулгүй байдлаа бататган бэхжүүлэхэд хангалттай хүч боломжтой байж, бусдад найдах биш өөрийн хүчинд тулгуурлах, зөвхөн өөрийн чадалд найдах үзлийг чухалчилдаг⁸ реалист шинжтэй гэж үзэж болохоор байна.

Тус бүс нутагт явуулж буй Британийн гадаад бодлого нь батлан хамгаалах-аюулгүй байдлын, эдийн засгийн болон хөгжлийн салбаруудад голчлон хэрэгжиж байгаа тул энэ хүрээнд гадаад бодлого хэрхэн явагдаж буйг товч авч үзье.

Батлан хамгаалах-аюулгүй байдлын салбар

Британийн гадаад бодлогын суурь үнэт зүйл нь иргэдийн болон улсын эрх ашиг, аюулгүй байдал. Энэ утгаараа

батлан хамгаалахын салбартаа онцгой ач холбогдол өгч жилд гурван тэрбум фунтын хөрөнгө оруулалт хийдгээрээ

⁶ Integrated Review Refresh 2023, Responding to a more contested and volatile world, 2023

⁷ Төвийг сахих уу? Хүчний тэнцвэр үү? <http://www.baabar.mn/article/7719>

⁸ С.Дашцэвэл, “Олон улсын харилцааны реалист онол ба үндэсний аюулгүй байдал: Хувьсал өөрчлөлт”, Олон улс судлал сэтгүүл, Улаанбаатар, 2002, 107 дугаар тал

европ тивдээ нэгд, НАТО-д хоёрдугаарт ордог аюулгүй байдал, тагнуулын салбараар дэлхийд тэргүүлэгч гүрэн юм.

Сүүлийн үед Энэтхэг-Номхон далайн бүс нутагт өрнөөд буй Хойд Солонгосын цөмийн зэвсгийн асуудал, БНХАУ болон Энэтхэгийн хилийн маргаан, Энэтхэг-Пакистаны зөрчил, Тайваний асуудал, олон улсын энх тайванч, нээлттэй, тогтвортой орших дэг журмыг зөрчиж буй БНХАУ-ын явуулж буй бодлого зэрэг үйл явдлууд⁹ тус улсын гадаад бодлогодоо баримталдаг ардчилал, хүний эрх, тэгш байдал зэрэг суурь зарчмуудыг зөрчиж байгаа тул Британийн анхаарлыг аргагүй татаж байна.

Британи Улс Энэтхэг-Номхон далайн бүс нутагт хамгийн нөлөө бүхий, хүчирхэг улсыг БНХАУ гэж үздэг боловч тус улсын талаарх байр суурь, баримтлах бодлогод нь өөрчлөлт ажиглагдсаар байна. БНХАУ-ын эдийн засаг, хүн ам, технологийн ололт амжилт, “Нэг бүс нэг зам” зэрэг томоохон санаачилга, хөтөлбөрүүдээр дамжуулан олон улсад үзүүлэх нөлөөлөл асар их юм гэдгийг хүлээн зөвшөөрч 2021 оны баримт бичигт БНХАУ-ыг өнөө үеийн геополитикийг тодорхойлогч улс гэж үзэж байжээ. Гэсэн хэдий ч Коммунист намын удирдлага доорх БНХАУ-ын түрэмгий, авторитар шинжтэй үйлдлүүд¹⁰ нь

Британийн аюулгүй байдалд, цаашлаад олон улсын аюулгүй байдалд сөрөг нөлөөтэй, Британийн хамгийн чухал ашиг сонирхол болох үндэсний аюулгүй байдал, НҮБ, олон улсын гэрээгээр хүлээсэн үүрэгт харшилж байна хэмээн үзэж байна. 2023 оны бодлогын баримт бичигтээ БНХАУ-ыг өнөө цагийн олон улсын харилцааны хамгийн том аюул буюу сорилт гэж үзэх болсон бөгөөд, БНХАУ-ын эсрэг өөрийн орны аюулгүй байдлаа бэхжүүлэх, энэ хүрээнд түнш орнуудтайгаа хамтран ажиллах бодлогыг баримтална гэжээ.

Британи Энэтхэг-Номхон далайн бүс нутагт анхаарах болсноос хойш тус бүс нутагт батлан хамгаалах салбарын хүрээнд идэвхтэйгээр хоёр талт болон олон талт хамтын ажиллагааг хөгжүүлж байна. Жишээ болгон дурдвал Британийн эзэн хааны усан цэрэг БНАСАУ-ын эсрэг цөмийн зэвсэг үл дэлгэрүүлэх хоригийг улам бэхжүүлэхээр БНСУ-ын усан цэрэгтэй хамтарсан эргүүл ажиллуулахаар тохиролцоод байна¹¹. Түүнчлэн Япон болон Итали улстай хамтран *Global Combat Air Program* буюу өөрсдийн шинжлэх ухаан, инновацид суурилсан шинэ үеийн агаарын нисэх хүчний хөтөлбөр хэрэгжүүлэхээр 2022 онд хэлэлцээрт хүрсэн¹².

Олон талт хамтын ажиллагааны хүрээнд 2021 онд Австрали, АНУ-тай

⁹ UK Defence and the Indo-Pacific <https://publications.parliament.uk/pa/cm5803/cmselect/cmdfence/183/report.html#heading-0>

¹⁰ БНХАУ-ын Тайваний эсрэг явуулж буй бодлого, авч буй арга хэмжээнүүдийг нь Британийн тал буруушааж байгаа бөгөөд олон улсын дэг журамд баримтлах чөлөөт, нээлттэй, ардчилсан зарчмыг зөрчиж байгаа үйлдэл гэж үзэж байна. Мөн ОХУ-ыг дэмжсэн шийдвэрүүдээс нь шалтгаалан БНХАУ-тай болгоомжлох байр сууринаас харилцах хандлагатай болсон.

¹¹ What's Next for the South Korea-UK Relationship? <https://thediplomat.com/2023/12/whats-next-for-the-south-korea-u-k-relationship/>

¹² The Global Combat Air Programme: The First Round of Hard Choices? <https://www.rusi.org/explore-our-research/publications/commentary/global-combat-air-programme-first-round-hard-choices>

хамтран гурван талт аюулгүй байдлын түншлэл болох АУКУС¹³-ийг үүсгэн байгуулсан билээ. АУКУС-ийн үндсэн зорилгын тэргүүнд Энэтхэг-Номхон далайн бүс нутагт аюулгүй байдлыг сахин хамгаалахын тулд ахисан түвшний цэргийн чадамжийг хамтдаа бүрдүүлэхээр тохиролцож, хиймэл оюун ухаан, шинжлэх ухаан, технологи, мэдээллийн хүчин чадалдаа суурилснаар энэхүү үр дүнд хүрнэ гэж үзсэн байна.

Тухайн бүс нутагт олон талт хамтын

ажиллагаанд эрчимтэйгээр оролцож эхэлсний бас нэгэн том жишээ нь 2022 оны 8 дугаар сард Британи АСЕАН-ы яриа хэлэлцээрийн түншийн статусыг авсан явдал бөгөөд АСЕАН-ы бүсийн чуулга уулзалтанд оролцох хүсэлтээ тавиад буй. АСЕАН бол тус бүс нутаг дахь хамгийн том хамтын ажиллагаа гэж тооцогддог бөгөөд Энэтхэг-Номхон далайн бүс нутагт Британийн оролцоог улам бүр бэхжүүлж, бататгах гол түншлэл байх болно гэж үзэж байна.

Эдийн засгийн салбар

БРЕКСИТ-ээс хойш Британи Европын нэгдсэн зах зээлд харьяалагдахгүй болж, бие дааснаар эдийн засаг, худалдааны хувьд ихээхэн алдагдал хүлээсэн бөгөөд энэ алдагдлаа эдийн засгийн томоохон бүс нутаг болох Энэтхэг-Номхон далайн бүс нутагт чиглэсэн бодлогоор нөхөх гэж байгаа талаар судлаачид бичих болсон¹⁴. Британи энэ бүсийн ихэнх улс орнуудтай хоёр талын худалдааны харилцаатай бөгөөд энэ бүс нутагт хийх Британийн худалдаа 2022 оны дүнгээр 250 тэрбум ам.долларт хүрчээ¹⁵. Энэ харилцаагаа хадгалахын тулд Британи маш идэвхтэй ажиллаж, богино хугацаанд буюу 2021 онд Японтой, 2023 онд Австрали, Шинэ Зеланд улсуудтай тус тус Чөлөөт худалдааны хэлэлцээрийг байгуулаад байна¹⁶.

Тус бүс нутагт явуулж буй эдийн засгийн бодлогын томоохон илрэл нь СРТРР¹⁷ буюу Номхон далай дамнасан иж бүрэн, дэвшилтэт түншлэлийн хэлэлцээрт нэгдэхээр хүсэлт гаргасан явдал юм. Тус хэлэлцээрт нэгдэх асуудал 2024 онд шийдвэрлэгдэх бөгөөд хэрэв Британи нэгдэж чадвал тус хамтын ажиллагааны анхны Номхон далайн бүс гишүүн орон болох юм¹⁸. Энэ хэлэлцээрт нэгдэх нь Европын холбооны Чөлөөт худалдааны хэлэлцээрийг орлуулах боломж гэж харж байгаа боловч БРЕКСИТ-ээс үүдсэн эдийн засгийн алдагдлыг богино хугацаанд нөхөх боломжгүй. Засгийн газрын тооцоолсноор 2040 он гэхэд ДНБ 2,4 тэрбум ам.доллараар буюу 0,06%-иар, СРТРР гишүүн орнуудтай хийх хоёр талын худалдаа 6 тэрбум ам.доллараар

¹³ AUKUS – Australia, the United Kingdom, the United States

¹⁴ Magnus Smidak, A Global Influencer? Global Britain and the Integrated Review, 2021

¹⁵ Indo-Pacific tilt: Foreign Secretary's speech, September 2022

¹⁶ <https://www.brookings.edu/articles/the-uks-indo-pacific-tilt-and-the-cptpps-prospects/>

¹⁷ Comprehensive and Progressive Agreement for Trans-Pacific Partnership

¹⁸ The UK's Indo-Pacific tilt and the CPTPP's prospects <https://www.brookings.edu/articles/the-uks-indo-pacific-tilt-and-the-cptpps-prospects/>

буюу 3,9%-иар нэмэгдэнэ гэсэн таамаг байна.¹⁹

Энэтхэг-Номхон далайн бүс нутагт явуулж буй Британийн гадаад бодлогоос харахад АУКУС, АСЕАН, СРТРР зэрэг олон талт хамтын ажиллагаанд идэвхтэйгээр нэгдэж, өөрийн байр

суурийг улам баталгаажуулахад анхаарч байгаа нь БРЕКСИТ-ээр алдсан олон талын холбоо, худалдаа эдийн засгийн давуу талаа энэхүү бүс нутгаас олж авахыг эрмэлзэж байгаа байдал гэж үзэж болно.

Хөгжлийн хамтын ажиллагаа

2022 оны 5 дугаар сард “ИБУИНХУ-ын Засгийн газрын Олон улсын хөгжлийн стратеги”²⁰ баримт бичиг батлагдан гарснаар Британийн хөгжлийн бодлогууд Энэтхэг-Номхон далайн бүс нутагт ямар хүрээнд, ямар чиглэлд явагдахыг тодорхойлж өгсөн байдаг. Энэ нь Британи олон улсын хөгжлийн асуудлыг гадаад яамны нэгэн чиглэл болгож өгсөнтэй холбоотой юм. Гадаад, хамтын нөхөрлөлийн яам болон Хөгжлийн яам гэсэн тусдаа яамд байсныг 2020 онд *Гадаад, хамтын нөхөрлөл, хөгжлийн яам* болгон нэгтгэснээс хөгжлийн асуудал тус улсын гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болсныг харах боломжтой. Ийнхүү хөгжлийн асуудал нэгэнт гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болсон бөгөөд 2023 онд буюу Олон улсын хөгжлийн стратеги батлагдсанаас хойш нэг жилийн дараах тайландаа Хөгжлийн бодлогоо хэрэгжүүлэх 5 суурь²¹ чиглэлийг НҮБ-ын Тогтвортой хөгжлийн 17 зорилгод тулгуурлан, дараах байдлаар томъёолсон байна:

1. Шударга, найдвартай хөрөнгө оруулалт;
2. Охид, эмэгтэйчүүдийн оролцоо, тэгш эрх;

3. Хүмүүнлэгийн тусламж, нийгмийн хариуцлага;
4. Уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчин;
5. Даян дэлхийн эрүүл мэнд.

Британи бусад улс орнуудад хандсан хөгжлийн бодлогуудаа эдгээр нийтлэг таван чиглэлийн хүрээнд явуулж байгаа боловч бүс нутаг, улс орон тус бүрд харилцан ялгаатай чиглэл баримталж байгаа нь бүс нутгийн болон тодорхой нэг улсын хөгжлийн түншлэлийн хураангуй бичгээс харагдана.

“Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн хөгжлийн түншлэлийн хураангуй”²²-д Энэтхэг-Номхон далайн бүс нутгийг Британийн эдийн засаг, аюулгүй байдал болон үнэт зүйлд чухал ач холбогдолтой, шийвэрлэх бүс нутаг²³ гэж тэмдэглээд энд түүхэн харилцаатай Хамтын нөхөрлөлийн орнууд болох Энэтхэг улс болоод номхон далайн улсууд байрладаг гэдгийг онцолсны дээр өлсгөлөн болон уур амьсгалын өөрчлөлт, хүрээлэн буй орчны доройтолд өртөх өндөр эрсдэлтэй бүс нутаг гэж тодорхойлжээ.

Британийн зүгээс Энэтхэг-Номхон

¹⁹ Мөн тэнд

²⁰ The UK Government’s Strategy for International Development, May 2022

²¹ Policy Paper Delivering the UK’s International Development Strategy: 2023 Progress Update, 29 August 2023

²² UK-Indo Pacific region development partnership summary, July 2023

²³ Мөн тэнд, 25 дугаар тал

далайн бүс нутагт дараах салбаруудад хөгжлийн хамтын ажиллагааг санал болгож байна:

- Уур амьсгалын өөрчлөлт;
- Ногоон дэд бүтэц;
- Худалдаа, эрчим хүч, эдийн засгийн холбоо;
- Охид, эмэгтэйчүүдийн оролцоо, тэгш эрх;
- Хүмүүнлэг, эрүүл мэнд, хүнсний

аюулгүй байдал.

Британийн Засгийн газрын зүгээс Хөгжлийн албан ёсны тусламжид ногдох төсвийг дунджаар ҮНБ-ий 0,5-0,7%-д байлгахаар зорьдог бөгөөд²⁴ 2023-2024 онд хөгжлийн албан ёсны тусламжийн төсвөөс Энэтхэг-Номхон далайн бүс нутгийн хөгжилд 24,4 сая, 2024-2025 онд 50 сая фунт ногдуулсан байна.


2. Бодлогын баримт бичгүүдэд Монгол Улсыг тусгасан нь

Өмнө хэлсэнчлэн “*Integrated Review of Security, Defence, Development and Foreign Policy*” 2021, “*Integrated Review Refresh*” 2023 баримт бичгүүдэд Энэтхэг-Номхон далайн стратегийг дэмжиж, энэ бүс нутагт анхаарлаа хандуулж буйгаа зарлан, энэ бүс нутгийн орнуудтай хийх бодлогоо улс улсаар нь

тодорхойлсон байдаг боловч Монгол Улсыг энэ бүс нутагт хамруулсан тухай заалт байдаггүй.

Харин 2023 оны Олон улсын хөгжлийн стратегийн тайланд²⁵ Монгол Улсыг Энэтхэг-Номхон далайн бүс нутагт хамруулан харуулсан байгааг доорх зурагнаас харах боломжтой.

Зураг 3. ОУХөгжлийн хөтөлбөрийг бүсчилж хэрэгжүүлж буй нь²⁶



²⁴ UK-Indo Pacific region development partnership summary, July 2023

²⁵ Policy Paper Delivering the UK's international development strategy: 2023 progress update, 29 August 2023

²⁶ Delivering the UK's international development strategy: 2023 progress update

Түүнчлэн 2023 онд тохиосон Монгол-Британийн дипломат харилцааны 60 жилийн ойн хүрээнд Британид хэвлэгдсэн “Дипломат” сэтгүүлийн тусгай дугаарын өмнөх үгэнд Британийн Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн яамны Энэтхэг-Номхон далайн асуудал хариуцсан сайд Анн Мэри Трэвэльян мэндчилгээ дэвшүүлж, Британийн Монголтой харилцах харилцааг “*maih их үнэ цэнтэй харилцаа*” хэмээн мэдэгдсэн²⁷ билээ. Эдгээрээс үзэхэд Британи Монгол Улсыг Энэтхэг-Номхон далайн бүс нутагт хамруулан авч үздэг гэж ойлгож болохоор байна.

2024 оны гуравдугаар сард Олон улсын хөгжлийн стратегийг дагалдан “Монгол Улсын түншлэлийн бичиг”²⁸ нийтлэгдсэн бөгөөд тус бичигт:

*“Монгол Улсын ‘гуравдагч хөрш’-ийн хувьд Британи нь Монголын тогтвортой, бат бөх ардчиллыг өөрийн орны Энэтхэг-Номхон далайн бүс нутаг дахь эрх ашигтай уялдуулан дэмжиж, хоёр болон олон талт хамтын ажиллагааг өргөн цар хүрээнд нэмэгдүүлэхийг зорьж байна.”*²⁹ гэжээ.

Энэхүү бичгээр манай улстай харилцах харилцааны голлох

чиглэлүүдийг дараах байдлаар тодорхойлсон байна:

- Худалдаа, хөрөнгө оруулалт;
- Уур амьсгалын өөрчлөлт;
- Ардчиллын үнэт зүйл;
- Боловсрол.

Өдгөө Британийн Хүрээлэн буй орчин, хүнс, орон нутгийн яамнаас (Defra)³⁰ Британийн Засгийн газрын шууд санхүүжилттэй гурван төсөл Монгол Улсад хэрэгжүүлж байгааг тус бичигт мөн оруулжээ³¹:

1. 2023 оноос хойш “Азийн уулсын зэрлэг ан амьтдыг хамгаалах олон нийт, байгаль хамгаалагчдыг чадавхжуулах” төсөл – Олон улсын цасны ирвэсийг хамгаалах сангаар дамжин хэрэгжиж буй;
2. 2021-2024 “Монголын шинэ экологийн цагдаа: Дэлхийн стандарт ба олон нийтийн оролцоо” төсөл - Лондоны амьтан судлалын нийгэмлэг хэрэгжүүлж буй;
3. 2021-2024 “Хавтгай болон уугуул малчдын төлөө Монгол орны говь цөлийг хамгаалах” төсөл - Лондоны амьтан судлалын нийгэмлэг хэрэгжүүлж буй.

3. Монгол-Британийн харилцааны өнөөгийн байдал

Британи өөрийн гадаад бодлогоо Энэтхэг-Номхон далайн бүс нутагт эргүүлснээс хойш хоёр орны харилцаанд ямар өөрчлөлт гарч, тэдгээр нь хэрхэн илэрч буйг судлан харуулахын тулд хоёр

орны харилцааны өнөөгийн байдлыг авч үзэх зайлшгүй шаардлагатай юм. Ингэхдээ Британийн гадаад бодлогын шинэ баримт бичиг гарсан 2021 оноос хойш үеийг хамруулан үзье.

²⁷ Diplomat сэтгүүлийн тусгай дугаар, Лондон хот, 2023, 11 дүгээр тал

²⁸ UK-Mongolia Development Partnership Summary, March 2024

²⁹ Мөн тэнд

³⁰ Department of Environment, Food and Rural Affairs

³¹ UK-Mongolia Development Partnership Summary, March 2024

2023 онд тохиосон дипломат ойтой холбогдуулан хоёр тал 60 жилийн харилцаагаа эргэн харж, тодорхойлохдоо Монгол-Британийн харилцаа голчлон

худалдаа, хөрөнгө оруулалт, боловсрол, ардчилал, байгаль орчин, соёлын харилцаан дээр тулгуурладаг гэж санал нэгтгэжээ³².

Худалдаа, хөрөнгө оруулалтын хамтын ажиллагаа

Монгол, Британийн харилцааны тэргүүлэх чиглэл нь худалдааны хамтын ажиллагаа бөгөөд Британи бол манай улстай эрт үеэс худалдаа, арилжааны түүхэн харилцаатай байсан улс билээ.


Өдгөө манай хоёр орны худалдааны эргэлт 2023 оны эхний улирлын байдлаар сүүлийн дөрвөн улирлын дүн 203 сая фунт байна.³³ Үүнд Британийн экспорт 129 сая фунт байгаа нь дөрвөн улирлын өмнөх дүнгээс 33,8%-иар буурсан үзүүлэлт байхад, Британийн импорт 74 сая фунт байгаа нь 196%-ийн өсөлттэй дүн юм.

Доорх графикаас 2013 оноос хойш анх удаа 2022 онд Британийн Монголтой хийх худалдааны тэнцэл алдагдалтай гарсан буюу Монголын тал ашигтай


дүнтэй гарсан нь харагдана.

Монголын экспортын гол нэрийн бараа нь ноос ноолууран эдлэл байдаг бол, Британийн Монгол Улсад хийх экспортын гол бараа нь суудлын автомашин, төмөр замын болон үйлдвэрлэлийн тоног төхөөрөмж байна.³⁴

Хоёр орны худалдааны харилцааг дэмжих хэд хэдэн арга, механизм байдгаас дурдвал Монгол-Британийн худалдааны танхим 2010 онд Лондон хотод үүсэн байгуулагдсан бөгөөд “Монголд бизнес эрхлэх нь” сэдэвт семинарыг Лондон хотноо жил бүр тогмол зохион байгуулдаг. Хамгийн сүүлд дипломат харилцааны 60 жилийн ойн хүрээнд “Монголын



Зураг 4. Монгол-Британийн худалдаа (2013-2022)



Зураг 5. Монгол-Британийн худалдааны тэнцэл

Эх сурвалж: Trade and Investment Factsheets, September 2023

³² Diplomat сэтгүүлийн тусгай дугаар, Лондон хот, 2023.

³³ Trade and Investment Factsheets, Department for Business and Trade, 2023

³⁴ Д.Уламбаяр, “Монгол Улс, Нэгдсэн Хаант улсын харилцааны зангилаа асуудал: хүйтэн дайн ба брекситийн өмнөх хийгээд дараах үе”, Олон улс судлал-2023: Монголын Британи судлал, эшх эмхэтгэл, Улаанбаатар, 2023

Лондон дахь Бизнес Форум”-ыг 2023 оны 11 дүгээр сард зохион байгуулаад байна. Түүнчлэн Улаанбаатар хотод уг худалдааны танхимын охин танхим болох “БритЧам” байгуулагдаад удаагүй байгаа юм.³⁵

Британид тодорхой нэг улс болон бүс нутгийг хариуцан ажилладаг Ерөнхий сайдын худалдааны элч нар ажилладаг³⁶ бөгөөд Монгол Улсыг хариуцсан худалдааны элчээр Даниел Кочинский 2020 оны 10 дугаар сард томилогдсон билээ. Британийн худалдааны элч нар ихэвчлэн хоёр орныг хавсран хариуцдаг бол Даниел Кочинский Монголыг зөвхөн хариуцаж байгаа нь манай улсад ач холбогдол өгч байгаагийн илрэл гэж харж болохоор байна. 2020 онд томилогдсоноосоо хойш Монгол Улсад гурван удаагийн албан ёсны айлчлал хийгээд байгаа бөгөөд хамгийн сүүлд 2023 оны 4 дүгээр сард ирэхдээ хоёр орны хооронд агаарын тээврийг нэмэгдүүлэх талаар ярилцаад³⁷ буцсан нь ажил хэрэг болж, 2024 оны 1 дүгээр сарын 23-ны өдөр Зам, тээврийн хөгжлийн сайд С.Бямбацогт Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улсаас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд Фиона Блайт нар “Агаарын харилцааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Их Британи, Умард Ирландын Нэгдсэн

Хаант Улсын засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийг байгуулсан юм. Үүний үр дүнд хоёр орны хооронд шууд нислэг гүйцэтгэхээс гадна Европ болон Төв Азийн орнуудаар дамжин нисэх боломж бүрдэж байна.³⁸

Түүнээс гадна Британийн Засгийн газрын тарифын нэн тааламжтай нөхцөлийн шинэ дэглэм буюу “Британийн Глобал тариф (*UK Global Tariff*)”-ыг 2020 оны 5 дугаар сард зарласан нь хоёр худалдааны харилцаанд чухал алхам болсон билээ. Ингэснээр БРЕКСИТ-ийн нөлөөгөөр Европын холбооны худалдааны Ерөнхий схемийг Британитай хийх худалдаандаа эдэлж чадахгүйд хүрээд байсан Монгол Улс 2021 оны 1 дүгээр сараас эхлэн худалдааны хөнгөлөлттэй тарифыг Британийн Глобал тарифын хүрээнд үргэлжлүүлэн эдэлж эхэлсэн³⁹. Түүний сацуу 2023 оноос Британийн “Хөгжиж буй орнуудын худалдааны схем”-д албан ёсоор элсээд байна⁴⁰.

Хоёр орны харилцаанд хөрөнгө оруулалт жинтэй хувь нэмэр эзэлдэг нь гарцаагүй. Мэдээж Британи-Австралийн хамтарсан Рио Тинто группийн Оюу толгойд оруулсан хөрөнгө оруулалт бол Монгол Улсад “гуравдагч хөрш”-өөс хийгдсэн хамгийн том хөрөнгө оруулалт гэж тооцогддог.⁴¹ Гэвч Оюу толгой төсөл анх эхэлсэн

³⁵ Diplomat сэтгүүлийн тусгай дугаар, Лондон хот, 2023, 17 дүгээр тал

³⁶ Prime Minister’s Trade Envoys <https://www.gov.uk/government/groups/trade-envoys>

³⁷ UK-Mongolian relations, House of Commons, 10 July 2023

³⁸ Монгол Улс дэлхийн 44 улсын 155 цэг рүү шууд нислэг үйлдэх боломжтой боллоо. <https://www.mnb.mn/i/308909?fbclid=IwAR1XmKuvth-n0AKrvyPI8ZAw55RH5JWKYyNM20IOzBJCXNkvBHgmXpNRkow>

³⁹ Д.Уламбаяр, “Монгол Улс, Нэгдсэн Хаант улсын харилцааны зангилаа асуудал: хүйтэн дайн ба брекситийн өмнөх хийгээд дараах үе”, Олон улс судлал-2023: Монголын Британи судлал, эшх эмхэтгэл, Улаанбаатар, 2023

⁴⁰ Diplomat сэтгүүлийн тусгай дугаар, Лондон хот, 2023, 54 дүгээр тал

⁴¹ Мөн тэнд

үеийн тооцоолол алдагдаж, Монголын тал бараг ашиг авахааргүй нөхцөл байдал үүссэнтэй холбоотойгоор 2019 онд “Оюу толгой ордын ашиглалтанд Монгол Улсын эрх ашгийг хангуулах тухай” УИХ-ын тогтоол батлагдан гарч, түүнээс хойш хоёр гаруй жилийн турш ихээхэн хүнд нөхцөлд яриа хэлэлцээр үргэлжилсээр 2022 оны 1 дүгээр сарын 25-нд Оюу толгойн гүний уурхайн бүтээн байгуулалтыг эхлүүлсэн билээ. Ингэснээр “Оюу толгой үйлдвэрлэлийн бүрэн хүчин чадлаараа ажиллаж эхлэхэд жилд 6 сая гаруй цахилгаан автомашин үйлдвэрлэх хэмжээний зэс нийлүүлнэ” гэж Рио Тинто группийн гүйцэтгэх захирал мэдэгджээ. Түүнчлэн гүний олборлолт бүрэн хүчин чадлаараа ажиллавал жилд 5 орчим тэрбум ам.долларын борлуулалт хийж, Монгол Улсын нэг жилийн эдийн засгийн тэн хагасыг Оюу толгой дангаараа үйлдвэрлэх боломжтой болох юм.⁴²

Боловсролын салбарын хамтын ажиллагаа

Хоёр орны харилцаа боловсролын салбарт мөн өргөн хүрээнд явагддаг. Кэмбрижийн боловсролын хөтөлбөр Монгол Улсад хэрэгжээд 10 жил болсон бол Pearson англи хэлний хөтөлбөр мөн хэрэгжиж эхлээд удаагүй байна. Британийн Засгийн газрын тэтгэлэгт хөтөлбөр болох Чевнинг хөтөлбөр манай улсад хэрэгжиж эхлээд даруй 30 гаруй жил болжээ. Энэ хугацаанд

Энэхүү Оюу толгойн хөрөнгө оруулалтын туршлагыг сайн туршлага хэмээн үзэж Британийн Засгийн газрын зүгээс дотоодын бизнес эрхлэгчдэдээ Монголд бизнес хийхийг уриалан, хөрөнгө оруулагчдаа дэмжин ажиллаж байна⁴³. Ингэхдээ Монголын байгалийн баялгийн нөөцийг онцолж байгаа бөгөөд Оюу толгой бол зөвхөн мөсөн уулын орой хэсэг нь гэж харж байгаа юм. Ялангуяа дэлхий нийтээр уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэж, тогтвортой хөгжил, ногоон дэд бүтцэд анхаарлаа хандуулж байгаа энэ цаг үед сэргээгдэх эрчим хүч, байгальд ээлтэй технологид хэрэглэгдэх үнэ цэн нь өсөн нэмэгдэж байгаа критикал минералуудын нөөц ихтэй Монгол Улсад бизнес эрхлэхийг уриалж байгаа нь Эзэн хааны Зүүн Европ, Төв Азийг хариуцсан худалдааны комиссар Кенан Полеогийн ярианаас харагдаж байна⁴⁴.

ойролцоогоор 200 гаруй Монгол оюутан Британи улсад төрөл бүрийн чиглэлээр суралцаж, магистрын зэрэг эзэмшсэн байна. Жилд дунджаар 10-12 Монгол оюутан хамрагддаг байсан бол 2023 онд 18 оюутныг хамруулсан⁴⁵. Энэ тоог цаашид хоёр дахин нэмнэ гэдгээ Британийн Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн сайд Дэвид Камерон манай улсад

⁴² Д.Уламбаяр, “Монгол Улс, Нэгдсэн Хаант улсын харилцааны зангилаа асуудал: хүйтэн дайн ба брекситийн өмнөх хийгээд дараах үе”, Олон улс судлал-2023: Монголын Британи судлал, эшх эмхэтгэл, Улаанбаатар, 2023

⁴³ Diplomat сэтгүүлийн тусгай дугаар, Лондон хот, 2023, 16 дугаар тал

⁴⁴ Британийн Засгийн газар бизнес эрхлэгчдээ дэмжиж, www.great.gov.uk вэб хуудсаар дамжуулан мэдээлэл түгээн, бизнес эрхлэгчдээ нэгтгэдэг.

⁴⁵ ИБУИНХУ-аас Монгол Улсад сууж асан Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Филип Малоуны ярилцлага, Британи судлал сэтгүүл, Улаанбаатар, 2023

хийсэн айлчлалынхаа үеэр⁴⁶ мэдэгдээд байгаа юм. Түүнээс гадна боловсролын салбарыг ихэд онцолж, хэдий богино хугацааны айлчлал хийсэн боловч Нийслэлийн 23-р дунд сургуулийн үйл ажиллагаа, англи хэлний хөтөлбөрийн

хэрэгжилттэй биечлэн танилцаж, манай улсад англи хэлний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд ирэх гурван жилд 10 сая фунтын дэмжлэг үзүүлэхээ амлаад буцсан билээ.⁴⁷

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын ажиллагаа

Худалдаа, хөрөнгө оруулалтын болон боловсролын салбартай эн зэрэгцэн ач холбогдол нь нэмэгдэж, идэвхжиж буй салбар бол уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг, тогтвортой хөгжлийн зорилтыг хэрэгжүүлэх хамтын ажиллагаа болж байна.

Британи Улс өөрөө энэ хүрээнд олон улсад хамгийн идэвхтэй үйл ажиллагаа явуулж, дэлхийн бусад орныг уриалан, дагуулж яваа улсын нэг бөгөөд 2021 онд Глазгоу хотноо НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн чуулга уулзалт буюу COP26-г удирдан зохион байгуулах үеэр Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх “Тэрбум мод” хөтөлбөрөө олон улсын удирдагч нарт танилцуулсан бөгөөд Британийн талаас энэхүү хөтөлбөрийг уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг Монгол Улсын зүгээс гаргаж буй чухал хүчин чармайлт гэж харан, дэмжиж буй.

Байгаль орчны чиглэлийн хамтын ажиллагааны өөр нэгэн жишээ бол Лондонд төдийгүй дэлхийд алдартай байгаль хамгааллын ууган байгууллага болох “Лондонгийн амьтан судлалын

нийгэмлэг” 2003 оноос Монгол Улсад үйл ажиллагаагаа эхлүүлж, 2017 онд Монгол дахь төлөөлөгчийн газраа нээсэн явдал билээ.⁴⁸ Сүүлийн таван жилд тус нийгэмлэг Монгол Улсад Зэрлэг амьтан, ургамлын хууль бус худалдааг бууруулах чиглэлд нийт 2,1 сая фунтын санхүүжилт бүхий 4 төсөл хэрэгжүүлжээ. Мөн өмнө дурдсан “Монголын шинэ экологийн цагдаа: Дэлхийн стандарт ба олон нийтийн оролцоо”, “Хавтгай болон уугуул малчдын төлөө Монгол орны говь цөлийг хамгаалах” төслүүдийг хэрэгжүүлж байгаа юм.

Дээрх салбаруудын хамтын ажиллагаанаас гадна хоёр орны харилцааны хөгжлийн хандлага, ач холбогдлыг илтгэх бас нэгэн чухал үзүүлэлт бол дээд хэмжээний харилцан айлчлалуудын давтамж, тэдгээрийн үр дүн мөн билээ. Хоёр орны төрийн дээд хэмжээний айлчлалуудыг харахад өмнө нь Монголын талаас хийгдсэн айлчлалууд давамгайлж байсан бол⁴⁹ Энэтхэг-Номхон далайд

⁴⁶ Дэвид Камерон: Бид хөгжлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаа гурав дахин нэмэгдүүлнэ https://gogo.mn/r/1ewgv?fbclid=IwZXh0bGZhZWMTEAAR3VS-5Oj1SL0h_BcIp7tckT_x3CCR6IH1uim1tEBAkv7e8FVfdNsyNcScDo_aem_AeCVNwYurnprenwm1Vc8hV8bU55-RFuPiTPv54NPCVH71CGU5viEYO7-tMYAKpZlgXYaZmQfDB40L7luE1rOaYak

⁴⁷ https://www.meds.gov.mn/post/155224?fbclid=IwZXh0bGZhZWMTEAAR0kGw39AD9Q70SMiFIh7OegXLNNUB6n_AbmfOX-O6Uy3t0Av1iT0DLrSg_aem_AdP6wG2cyFyMQZVAO1TVFALo5SAvtsD6x9ybTKLpE676J8qdKYZlvZVTuuyGyr_3eBg9Y1rsl3mFSnWWyissgA

⁴⁸ У.Тунгалаг, “Монголын байгаль хамгаалалд Британи улс”, Британи судлал сэтгүүл, Улаанбаатар, 2023

⁴⁹ Тив дамнанас хөршүүд, ШУА-Олон улс судлалын хүрээлэн, Улаанбаатар, 2014, 242-254-р тал

чиглэсэн бодлогын хүрээнд Британийн айлчлалууд нэмэгдэх хандлагатай болсныг Британийн Монголд өгөх ач холбогдол өссөнтэй холбон тайлбарлаж болно.

Хамгийн сүүлд буюу 2024 оны 4 дүгээр сарын 25-26-ны өдрүүдэд Британийн Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн сайд Дэвид Камерон Монгол Улсад айлчилсан. Энэ нь Британийн Гадаад хэргийн сайдын түвшинд манай улсад хийж буй гурав дахь айлчлал болсон бөгөөд⁵⁰ айлчлалынхаа хүрээнд “*Бид хоёр талт түншлэлээ улам бэхжүүлэхийг хүсэж байна. ...Хөгжлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаа гурав дахин нэмэгдүүлж байна.*” гэж мэдэгдсэн билээ.

Дэвид Камероны айлчлал Гадаад хэргийн сайдын түвшинд Монгол Улсад хийгдсэн сүүлийн айлчлалаас 11 жилийн дараа болж байгаа бөгөөд энэ удаа дэлхийн дэг журам, үнэт зүйл, чиг хандлага тэс өөр болсон үед болж

буйгаараа анхаарал татаж байна. Ийм цаг үед манай улсад айлчилсан нь нэг талаар манай улсын геополитикийн онцлог, үр өгөөжтэй холбоотой байхыг үгүйсгэх аргагүй.

Ямартаа ч энэ удаагийн айлчлалаар хэд хэдэн чухал яриа хэлэлцээ хийгдсэн бөгөөд боловсролын салбараас гадна уул уурхайн салбарын хамтын ажиллагаагаа нэмэгдүүлэхээр тохиролцож, Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай Ховор металын чиглэлээр хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичиг байгуулсан⁵¹.

Түүнчлэн айлчлалын хамгийн гол үр дүн бол “Монгол Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс хоорондын хамтын ажиллагааг иж бүрэн түншлэлд хүргэх замын зураглал”-д гарын үсэг зурсан явдал байв. Энэ нь хоёр талын харилцааг Иж бүрэн түншлэлд хүргэх, Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрийг байгуулах суурь баримт бичиг болно.⁵²

4. Дүгнэлт

Монголын “гуравдагч хөрш”, эртний харилцаатай Британи улстай харилцах харилцаа олон улсын харилцааны дэг журам, хувьсалтай холбоотойгоор өөрчлөгдөн явсаар өнөөдөр хэзээ

хэзээнйхээсээ илүү ойр харилцаа үүсэх нөхцөл бүрэлдсэн гэж хэлж болохоор байна. Судлаачдын үзэж буйгаар дэлхийн дэг журам ахин хоёр туйлт болох нөхцөл үүссэнээс томоохон гүрнүүд Энэтхэг-

⁵⁰ “Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд ИБУИНХУ-ын Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн сайд Дэвид Камерон барааллав.” https://president.mn/29037/?fbclid=IwZXh0bgNhZW0CMTAAR1TsVOI9OuscPxt4m-TM5TqS49R7mSscNqWF3jCwi6DhOvboMSZ-2Yait4_aem_AdNPI0tI_Uk_zOsr-8IvQCtI6JoNfdYWF384f4AdmjwAsDtX-L2-Kn0xLijEyXFMTikErmUFTjOnPq4t5VK6W

⁵¹ <https://www.facebook.com/Ministryofmining/posts/pfbid0LiT5Yv61GRfAGg8LfhCPbaJafaSPfPkW9pxm89o1hqvnS1SgPPMNQsbcPrgkmp7l>

⁵² Монгол Улсын Гадаад харилцааны яам https://mfa.gov.mn/78469?fbclid=IwZXh0bgNhZW0CMTAAR1iOUPWoioPmIQepVq2DTAAfrIc_QIBvDhErQZXDATuHwRk5YY6EHRc0hA_aem_Aad7C7fneaa3axkZLulNNOtJgf3tloOeKols0IoP-UdK7Wmgjic4RSqvisVqhacaAaMTntMuxaXMEPAk_IF90c3

Номхон далайн бүс нутагт анхаарлаа хандуулах болсон энэ цаг үед хамгийн эгзэгтэй байрлалд оршиж буй Монгол Улс өөрийн гадаад бодлого, томоохон хөршүүдтэй харилцах харилцаандаа ихэд анхааран, тэдний бодлоготой уялдуулсан, ухаалаг чиглэлийг баримтлах шаардлагатай нүүр туллаа.

Нэгэнт Энэтхэг-Номхон далайн бүс нутаг нь Британийн гадаад бодлогын тулгуур чиглэл болон батлагдаж, тус бүс нутагт Монгол Улсыг оруулан авч үзсэн байгаагаас цаашид манай хоёр улсын харилцаа улам ахиж, идэвхэжнэ гэж таамаглаж болно. Хоёр улсын харилцаанд БРЕКСИТ-ээс хойш буюу Британи олон улсын тавцанд дангаар, бие дааж тоглолт хийж эхэлснээс хойш (эсвэл Британи Энэтхэг-Номхон далайн стратегийг дэмжиж, гадаад бодлогын шинэ чиглэлээ баталснаас хойш ч гэж үзэж болно) томоохон өөрчлөлтүүд ажиглагдсаар байгаа нь сүүлийн үеийн харилцааны гол үйл явдлуудаас тод харагдаж байна.

Оюутолгойн гүний уурхайн олборлолт хоёр жилийн турш хэлэлцээний шатанд явагдсаны эцэст хэрэгжиж эхэлсэн нь, Чевнинг тэтгэлгээр сургах оюутны тоо хоёр дахин нэмэгдсэн нь, мөн Монголыг хөгжиж буй орнуудын худалдааны схемд хамруулсан зэрэг нь бүгд цаг хугацааны хувьд үзвэл Энэтхэг-Номхон далайн бүс нутагт Британийн явуулж буй бодлогын хүрээнд хийгдсэн гэж үзэх үндэслэлтэй.

Хоёр талын хамтын ажиллагааны чиглэлүүдээс харахад Британийн зүгээс манай улсыг *Хөгжлийн бодлогынхоо* хүрээнд авч үзэж, бодлогоо хэрэгжүүлж байна. Хөгжлийн бодлогоор дамжаад цаашид Тогтвортой хөгжлийн зорилтыг хангах, уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг тэмцэхэд хоёр улс илүүтэй

хамтран ажиллах нь тодорхой. Үүний нэгэн илрэл болж Британийн Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн яам Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамтай Ховор металын чиглэлээр хамтран ажиллах тухай харилцан ойлголцлын санамж бичгийг үзэглэлээ. Үүнийг сэргээгдэх эрчим хүч, ногоон технологид хэрэглэгдэх Монголын критикал минералын олборлолт, хайгуул чиглэлээр ирээдүйд хамтран ажиллаж, цаашид Оюу толгой шиг Монголын эдийн засагт томоохон байр суурь эзлэх бүтээн байгуулалт манай улсад дахин эхлэх нөхцөл бүрэлдэн, суурь нь тавигдлаа хэмээн судлаачийн зүгээс харж байна.

Түүнчлэн, “Монгол Улс, Их Британи, Умард Ирландын Нэгдсэн Хаант Улс хоорондын хамтын ажиллагааг иж бүрэн түншлэлд хүргэх замын зураглал”-д хоёр тал гарын үсэг зурсан нь тал талаасаа харилцаагаа цаашид улам нягтруулж, гүнзгийрүүлэх сонирхолтой байгааг илтгэнэ. Харилцаагаа шат ахиулж чадвал худалдаа, хөрөнгө оруулалт, боловсрол, байгаль орчны үндсэн салбаруудаас гадна батлан хамгаалах, эдийн засгийн томоохон салбаруудад мөн хамтран ажиллах боломж нэмэгдэж, хоёр орны харилцааны чиглэлүүд олон салбарыг хамран, төрөлжих суурь тавигдах ач холбогдолтой юм. Манай улсын хувьд энэхүү замын зураглалд үндэслэлд нэн тэргүүнд харилцаагаа нэг шат ахиулан, Түншлэл, хамтын ажиллагааны хэлэлцээрт хүрэх ашиг сонирхол байгаа боловч энд хоёр хөрштэй харилцах харилцаандаа сэв суулгахгүйгээр, тэнцвэрийг барьж, болгоомжтойгоор эрх ашгаа хангах ухаалаг тоглолт хэрэгтэй.

Ном зүй / References:

Монгол хэл дээрх эх сурвалж

1. Анударь, Т, “Брекситээс хойших Энэтхэг-Номхон далайд чиглэсэн Британийн гадаад бодлого”, *Олон улс судлал-2023: Монголын Британи судлал эих эмхэтгэл*, Улаанбаатар, 2023
2. Дашцэвэл, С, “Олон улсын харилцааны реалист онол ба үндэсний аюулгүй байдал: Хувьсал өөрчлөлт”, *Олон улс судлал сэтгүүл*, Улаанбаатар, 2002
3. ИБУИНХУ-аас Монгол Улсад сууж асан Онц бөгөөд Бүрэн эрхт элчин сайд Филип Малоуны ярилцлага, *Британи судлал сэтгүүл*, Улаанбаатар, 2023
4. Оргил-Эрдэнэ, Ж, “АНУ-ын Энэтхэг-Номхон далайн стратеги: Их гүрнүүдийн өрсөлдөөний эрин үе дэх АНУ-Монголын харилцаа”, *Энэтхэг-Номхон далайн үзэл санаа: Оролцогч орнуудын байр суурь*, Улаанбаатар, 2022
5. *Тив дамнасан хөршүүд*, ШУА-Олон улс судлалын хүрээлэн, Улаанбаатар, 2014
6. Тунгалаг, У, “Монголын байгаль хамгаалалд Британи улс”, *Британи судлал сэтгүүл*, Улаанбаатар, 2023
7. Уламбаяр, Д, “Монгол Улс, Нэгдсэн Хаант улсын харилцааны зангилаа асуудал: хүйтэн дайн ба брекситийн өмнөх хийгээд дараах үе”, *Олон улс судлал-2023: Монголын Британи судлал, эих эмхэтгэл*, Улаанбаатар, 2023

Англи хэл дээрх эх сурвалж

1. *Diplomat* сэтгүүлийн тусгай дугаар, Лондон хот, 2023
2. *Integrated Review of Security, Defence, Development and Foreign Policy*, 2021
3. *Policy Paper Delivering the UK's International Development Strategy: 2023 Progress Update*, 29 August 2023
4. *The UK Government's Strategy for International Development*, May 2022
5. *Trade and Investment Factsheets*, Department for Business and Trade, 2023
6. *UK-Indo Pacific region development partnership summary*, July 2023
7. *UK-Mongolia Development Partnership Summary*, March 2024
8. *UK-Mongolian relations*, House of Commons, 10 July 2023

Цахим эх сурвалж

1. Дэвид Камерон: Бид хөгжлийн хөтөлбөрийн хөрөнгө оруулалтаа гурав дахин нэмэгдүүлнэ https://gogo.mn/r/1ewgv?fbclid=IwZXh0bgNhZW0CMTEAAR3VS-5Oj1SL0h_BcIp7tckTx3CCR6IH1uim1tEBAkv7e8FVfdNsyNcScDo_aem_AeCVNwyurnprenwm1Vc8hV8bU55-RFuPiTPv54NPCVH71CGU5viEYO7-tMYAKpZlgXYaZmQfDB40L7luE1rOaYak
2. Монгол Улсын Гадаад харилцааны яам https://mfa.gov.mn/78469?fbclid=IwZXh0bgNhZW0CMTEAAR1iOUPWoioPmIQepVq2DTAAfrIc_QlBvDhErQZXDATuHwRk5YY6EHRc0hA_aem_Aad7C7fneaas3axkZLulNNOtJgf3tloOeKoIs0IoP-UdK7Wmgjic4RSqvisVqhacaAaMTntMuxaXMEPAkIF90c3

3. Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхэд ИБУИНХУ-ын Гадаад хэрэг, хамтын нөхөрлөл, хөгжлийн сайд Дэвид Камерон бараалхав.
4. https://president.mn/29037/?fbclid=IwZXh0bgNhZW0CMТAАAR1TsVOI9OuscPxt4m-TM5TqS49R7mSscNqWF3jCwi6DhOvboMSZ-2Yait4_aem_AdNP10tLi_Uk_zOsr-8IvQCtl6JoNfdYWF384fF4AdmjwAsDtX-_L2-Kn0xLijEyXFMTikErmUFTjOnPq4t5VK6Whttps://www.meds.gov.mn/post/155224?fbclid=IwZXh0bgNhZW0CMТAАAR0kGw39AD9Q70SMiFIh7OegXLNNUB6n_AbmfoX-O6Uy3t0Av1iT0DLrSg_aem_AdP6wG2cyFyMQZVAO1TVFAIo5SAvtsD6x9ybTKLpE676Jj8qdKYZlvZVTuuyGyr_3eBg9Y1rspI3mFSnWWyisgA
5. Монгол Улсын Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам <https://www.facebook.com/Ministryofmining/posts/pfbid0LiT5Yv61GRfAGg8LfhCPbaJafaSPfPkW9pxm89o1hqvnS1SgPPMNQsbcPrgkmer7l>
6. Монгол Улс дэлхийн 44 улсын 155 цэг рүү шууд нислэг үйлдэх боломжтой боллоо. <https://www.mnb.mn/i/308909?fbclid=IwAR1XmKuvth-n0AKrvgPI8ZAw55RH5JWKYyNM20IOzBJCXNkvBHgmXpNRkow>
7. Төвийг сахих уу? Хүчний тэнцвэр үү? <http://www.baabar.mn/article/7719>
8. Prime Minister's Trade Envoys <https://www.gov.uk/government/groups/trade-envoys>

The United Kingdom's Indo-Pacific policy and Mongolia

Anudari Tuvshinjargal

*Institute of International Studies, Mongolian Academy of Sciences,
Ulaanbaatar, Mongolia
anudari_t@mas.ac.mn*

Abstract: *The study of Britain's current foreign policy is greatly influenced by the country's rich imperial and colonial history, historical position, and traditional policies. Britain's foreign policy stands out from other countries because it has ruled over many colonies from every continent, including Asia, Africa, America, even Europe and still has not lost its influence on those countries.*

How Brexit has affected the foreign policy of a great power that has been implementing its policy globally from the position of a colonialist throughout its history, how Britain is adapting to the many challenges that are taking place in the world today, and what policy direction it is shifting to must draw Mongolia's attention as Britain is one of our third-neighbor countries which was the first to establish diplomatic relations from Europe.

This article aims to explore how Britain's foreign policy has changed since Brexit and why it has become more focused on the Indo-Pacific, and to specifically study how Indo-Pacific policy of Britain reflects on its policy towards Mongolia.

Keywords: *Britain's foreign policy, Indo-Pacific, International development strategy, Mongolia-Britain relations*

The day of submission: 2024.07.15

Completion of Review: 2024.10.16

Final Decision for Acceptance: 2024.11.12